



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1066

танай _____-ны № _____-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монголын Социал Демократ Нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монголын Социал Демократ Нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


"Монголын Социал Демократ Нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030693



МОНГОЛЫН СОЦИАЛ ДЕМОКРАТ НАМЫН 2024 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ОРШИЛ

Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох энэ мөрийн хөтөлбөр нь Монгол улсын үндсэн хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан Монголын Социал Демократ Намын баримт бичиг болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засч, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах, авилга-хахууль, Үндэсний аюулгүй байдалд занал хийсэн үйлдийг зогсоох зорилгоор, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх хүрээнд, нотолгоо, мэдээлэл судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Монгол Улс төлөвлөснийхээ дагуу хөгжиж, дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхъя гэвэл дотоодын жижиг зах зээлд хоорондоо хэт өрсөлдөж, хүч нөөцөө барах бус, дэлхийн зах зээлд өрсөлдөх зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлсэн хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай.

Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд Монгол хүний төлөө анхаарч, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг хагалах чиглэл юм. Монгол Улсын орчин, нөхцөл байдал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзвэл дараах 3 чиглэл онц ач холбогдолтой бөгөөд эдийн засаг, нийгмийг хөгжлийн замд нь түргэн гаргахад түлхэц болно гэж бид үзэж байна.

Үүнд:

- Хүний хөгжил боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилд тууштай, бодитой хөрөнгө оруулах. Нэгд, энэ бол өнөөдрийн Монголд нэн тулгамдсан, хойш тавих боломжгүй асуудал, хоёрт, дунд болон урт хугацаанд олон том асуудлын шийдэл нь хүний хөгжил, гуравт, эрүүл монгол хүн өөртөө хөрөнгө оруулах, капитал бий болгох юм.

Технологийн хэрэглээ Блокчэйн, үндэсний хүнд үйлдвэрлэл, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх түвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэн, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь хүртэнэ.

Байгальд ойр Монгол Байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан уламжлалт монгол сэтгэлгээ, нүүдлийн соёл, амьдралын амар тайван хэв маягийг технологийн шийдэлтэй хослуулан хөгжүүлж, дэлхий дахинд ялгарах шинэ Монгол хэв маяг бүрдүүлнэ.

Монголчуудад хурд, хүч, ялгарлыг өгөх дээрх гурван тулгуурт үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой бодлогын арга хэмжээг дараах 5 бүлэгт ангилан оруулав.

Үүнд:

Хүндээ хөрөнгө оруулах Боловсролтой, Эрүүл “ЗӨВ МОНГОЛ” хүн эх орноо авч явна. Хүнсний аюулгүй байдал бэлчээрийн аж ахуй, мал, мах, байгалийн цэвэр орчинд ургуулсан химийн бордоогүй хүнсний ногоо, усны зохистой хэрэглээ саарал ус, цэвэр ус, нөөц усан сан зэрэг асуудлууд эн тэргүүний зорилт байх болно.

Дэлхийн технологийг түрүүлж эзэмших Шилдэг шинэ технологийг бусдаас өрсөн эзэмшиж, ашиглаж чадсан цагт гурван сая таван зуун мянган Монголуудын амьдрал гучин сая мэт болж чадна.

Байгальд ойр, зөв хөгжлийн үлгэрлэл Унаган байгаль, түргэн хөгжлийг хослуулж болдгийн үлгэр жишээг Монголчууд дэлхий ертөнцөд үзүүлж чадна.

Цэвэр төр, авлигагүй улс Төрөө авлигаас ангид байлгаж, хүчтэй болгож байж Монгол Улс сэргэн хөгжинэ.


Баялгийн зөв хуваарилалт, удирдлага, Байгалийн баялгийг эдийн засгийн зөв эргэлтийн бодлого л бүгдэд хүртээмжтэй орлого болгоно.

I. ХҮНДЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ

Боловсролтой, эрүүл, зөв монгол хүн эх орноо авч явна.

Шийдэл:

- Монгол түүх, хэл соёл, амьдрал ахуйгаа дээдэлдэг, орчин үеийн технологи, мэдээлэл харилцаа холбоо, сансрын орон зайн ашиглалт, гадаад хэлийг эзэмшсэн, дэг журмыг биелүүлдэг, хариуцлагатай, зөв хүн болгон хойч үеэ хүмүүжүүлэх сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, дээд боловсролын цогц бодлогыг дэмжинэ.
- Ерөнхий боловсролын агуулга, боловсон хүчин, тогтолцоо, сургалтын орчинг судалгааны үндэслэл дээр тулгуурлан сайжруулан бэхжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Мэргэжлийн боловсролын бодлогыг төрийн дээд түвшинд анхаарч хэрэгжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулан өргөн хэмжээгээр хэрэгжүүлэх бодлого баримтална.
- Дээд боловсролын хүрээнд судалгааны, инновацийн их сургууль болон хөгжих, академик эрх чөлөөг хангахыг дэмжинэ. Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын эрин үеийн шаардлага, чадварт нийцсэн боловсон хүчнийг бэлтгэн гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Дээд боловсрол, ахисан түвшний боловсролд онцгойлон анхаарч дэлхийн түвшний стандартад тэнцэх монголын боловсролтой иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг гардан гүйцэтгэгчдийг сурган бэлтгэхэд төрөөс бүх талын анхаарал тавихыг дэмжинэ.



- Гадаад улс оронд орчин үеийн өндөр технологи, инженерчлэлийн мэргэжил эзэмшсэн иргэдийнхээ мэдлэгийг улс орондоо нутагшуулан, улс орныхоо хөгжилд бодитой хувь нэмэр оруулахад онцгойлон анхаарч дэмжлэг үзүүлнэ.
- Хөдөө орон нутгийн малчин залууст шаардлагатай боловсрол, мэргэжил олгох хөтөлбөрийг төрөөс авч хэрэгжүүлэх ажлыг санаачлан дэмжинэ.

Боловсролын хүртээмж, сургалтын орчныг дээшлүүлэх.



Шийдэл:

- Бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд олон хувилбараар хамруулахад анхаарна. Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжинд хичээллэдэг тогтолцоог зорилт болгон хэрэгжүүлэхэд анхаарна.
- Сургуулийг өндөр хурдны интернэтэд бүрэн холбож, зайн сургалт, онлайн сургалтын орчин үеийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлээс үл хамаарсан тэгш хамруулах сургалтыг ерөнхий боловсролд бүрэн нэвтрүүлэхийг дэмжинэ. Үе тэнгийнхний дээрэлхэлт, цахим болон биет гадуурхалтыг бууруулна.
- Нийслэл хот, суурин хөдөө орон нутгийн сургууль, сургалтын орчинг ижил түвшинд хүргэхэд төрөөс хэрэгжүүлэх бүх ажлыг дэмжинэ.
- Сургуулийн өмнөх болон бага дунд сургуулийн хүүхдүүдийг үнэлэх үнэлэмжийг орчин үеийн шаардлагад хүргэхэд анхаарч дэлхийн түвшний сайн жишээг авч хэрэгжүүлэх ажлыг бүх шатны сургалтын байгууллагад хүргэхэд анхаарна.
- Төвөөс алслагдсан аймаг орон нутагт байрлах их дээд сургууль, МСҮТ, коллежийн санхүүжилт, сургалт судалгааны эд материалын дэмжлэг туслалцааг дэмжин ажиллах.

Боловсролын агуулгын тогтолцоо, боловсон хүчний шинэчлэл.

Шийдэл:

- Шавь төвтэй, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сургалтын арга барилыг бүрэн нэвтрүүлэхэд анхаарна. Сурах бичгийн шинэчлэлийн уялдаа холбоог бэхжүүлж, сургалтын хөтөлбөрийн тогтвортой хэрэгжилтийг хангахад анхаарна.
- Багш нарын цалинг амьдралд хүрэлцэхүйц болгох санал дэвшүүлнэ.
- Гадаад хэлний сургалтыг сайжруулж, Монгол улсын хэмжээнд “Хос хэлтэн” болох зорилтыг хангахад анхаарна. Бичиг үсгийн бодлогыг цэгцэлж, латин үсгийг интернэт орчинд, үндэсний монгол бичгийг хүндэтгэлийн хэрэглээнд тус тус хэрэглэхийг дэмжинэ.
- Мэргэжлийн сургалттай хослуулсан аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн гүнзгийрүүлсэн сургалтыг ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгахад анхаарна.
- Малчин тариаланчдыг эрхэлж байгаа аж ахуйгаа шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлан хөгжүүлж чадах туршлагатай болох хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд анхаарч зуд, ганд тэсвэртэй үр ашигтай тариалангийн ургамал, мал аж ахуйг бий болгон мэрэгшихийг дэмжинэ.

Эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийг оновчтой болгож үр ашгийг сайжруулж, иргэдэд хүртээмжтэй болгох.

Шийдэл:

- Эрүүл мэндийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог боловсронгуй болгох эрх зүйн орчинг бий болгож, дотоод гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтлана.
- Эрүүл мэндийн ажилтны үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарна. Эмч, сувилагч нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх хөшүүргийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын цалин хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарна. Эмч эмнэлгийн ажилтны орон тоог нэмэгдүүлэхийг дэмжинэ.

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үр нөлөөтэй тогтолцоо бий болгох.

Шийдэл:

- Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд болон, дүүрэг бүрт нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг бэхжүүлэн, иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, дадал, хандлагыг бүрдүүлэхэд анхаарна.
- Эмийн болон хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг чанд мөрдүүлнэ. Вакцин, эмийн хяналтын үндэсний лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулахад анхаарна.

Ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах.

Шийдэл:

- Нийгмийн тэгш байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн орлогын ялгааг багасгах эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, нийгэмд дундаж орлоготой хүчирхэг давхаргыг тэлэх бодлогыг дэмжинэ. Ажлын байрыг бий болгох замаар ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүргэж, тогтвортой бууруулахад анхаарч ажиллана.
- Хөдөлмөрийн харилцаанд хүн төвтэй хандлагыг бэхжүүлэхийг дэмжиж, Үйлдвэрчний эвлэлийн хөдөлмөрийн харилцааг бэхжүүлэхэд анхаарна. Хөдөө, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулна.
- Нийгмийн баялгийг зохистой, шударга хуваарилах, эдийн засгийн хөгжлийг тэтгэх татварын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт хамруулахад анхаарна.

Нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн шинэчлэл хийж, тэгш боломжийг бүрдүүлэх.

Шийдэл:

- Өндөр настнуудын амьдралын баталгааг хангах, ирээдүйд зориулж хуримтлал хийх тэтгэврийн даатгалын суурь болон хувийн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийг өвлөгддөг байхыг бүх талаар дэмжинэ.
- Нийгмийн халамжийн хүртээмж, оновчтой байдлыг сайжруулахад анхаарна. Эмзэг бүлгийн иргэдэд олгогдох нийгмийн халамжийг өрхийн үндсэн хэрэгцээнд хүрэлцэхүйц хэмжээнд хүргэх шинэчлэлийг дэмжинэ.



- Бага насны хүүхэд ядуурал, хүнс тэжээлийн дутагдал, орон гэргүйн улмаас амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь эрсдэх нөхцөл байдлыг арилгахад анхаарна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд орох хууль эрх зүй, биет болон нийгмийн орчныг бүрдүүлж, ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлэхэд нийгмийн бүх салбарт хэрэгжүүлэхэд анхаарна.

II. ДЭЛХИЙН ТЕХНОЛОГИЙГ ТҮРҮҮЛЖ ЭЗЭМШИХ

Шилдэг шинэ технологийг түрүүлж эзэмшсэн цагт гурван сая таван зуун мянган Монголчуудын амьдрал гучин сая мэт болж чадна
Мэдээллийн технологи хөгжих суурь нөхцлийг бүрдүүлнэ.
Технологийн боловсрол, хэрэглээг газар нутаг, хүн амын бүх түвшинд нэвтрүүлэн дэмжих.

Шийдэл:

- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны интернетийн сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Хот суурин, орон нутгийн бүх түвшинд интернэт хэрэглээг нэвтрүүлж, интернэт орчинг хямд хүртээмжтэй байлгахыг дэмжинэ.
- Ерөнхий, мэргэжлийн болон дээд боловсролын хөтөлбөрт мэдээллийн технологийн боловсролыг оруулахыг дэмжинэ.
- Технологийн боловсрол олгох зориулалттай лаборатори болон бусад сурах орчныг орчин үеийн шийдлийг ашиглан сургалтын байгууллагуудад эрчимтэй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Зайны болон онлайн сургалтын хэлбэрийг ашиглан насан туршийн болон эцнээ боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна.
- Хүний хөгжил, авъяас ур чадварт суурилсан коллеж, МСҮТ-ийн архитектур, дизайн, урлаг зэрэг салбарыг хүүхэд залуусын сонирхол хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлэхийг дэмжинэ.
- Технологи, инженерчлэлээр дэлхийн тэргүүлэх их сургуулиудад залуучуудыг суралцуулах бодлого, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг бүх талаар дэмжинэ.

Технологийн шинэ шийдлүүдийг эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэх.

Шийдэл:

- Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын технологийн шийдлүүдийг уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, худалдаа, зам тээвэр, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, нийгмийн харилцаанд өргөнөөр нэвтрүүлэхэд анхаарна.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн их өгөгдлийг бий болгож төрийн бодлогыг судалгаа, мэдээлэлд суурилж гаргадаг болгоход анхаарна.
- Монгол орны газрын хэвлий, мал амьтан, ургамлын гаралтай түүхий эдийг ашиглан үйлдвэрлэх өндөр технологийн бүтээгдэхүүн, материал судлалын салбарыг хөгжүүлэхэд анхаарна.
- Бэлчээрийн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, малын гаралтай түүхий эдийн цахим мөшгих системийг хэрэгжүүлэхэд анхаарна.



- Технологийг дэмжих татварын бодлого болон санхүүгийн хөшүүргийг хэрэгжүүлэхийг бүх шатны төрийн байгууллагуудад хэрэгжүүлэхэд анхаарна.

III. БАЙГАЛЬД ОЙР ЗӨВ ХӨГЖИЛ

Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж болдгийн үлгэр жишээг Монголчууд дэлхий ертөнцөд үзүүлж чадна.

Уламжлалт эко соёлыг эрхэмлэгч, байгаль орчны сүйрлийн эсрэг манлайлагч улсын хувьд ногоон бизнесээр тэргүүлэгч улс болно.

“Байгальд ойр Монгол” хөгжлийн загвар.

Шийдэл:

- Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг манлайллыг дэмжиж, бүх салбаруудад байгаль орчинд ээлтэй соёлыг нэвтрүүлж, уламжлалт эко соёлыг бизнесийн боломж болгохыг дэмжинэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх иж бүрэн систем бий болгох тогтолцоонд анхаарна.
- Хүлэмжийн хий бууруулах, байгаль хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах зориулалттай төр хувийн хэвшил хамтарсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтлана.
- Хувийн хэвшлийн оролцоо, хариуцлага, хөрөнгө оруулалтыг түлхүү татан оруулах, ногоон зээл санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын орчин бий болгоход анхаарна.
- Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд ард иргэдийг аврах, нүүлгэн шилжүүлэх, хамгаалах тухай сургалт судалгаа явуулах, сургах.
- Байгальд ойр монгол хөгжлийн үндсэн загварыг бүсчилсэн хөгжлөөр бий болгон, төрд төвлөрүүлэх бус бүсүүдэд хөгжлийн бодлогыг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгон иргэдийг хөдөө орон нутаг руу татах бодлогыг хэрэгжүүлэхийг дэмжинэ.

Бохирдлыг бууруулж, байгалийн нөөц, экосистемийг хамгаалах.

Шийдэл:

- Усны нөөцийг хамгаалан, нэмэгдүүлж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амыг 85% (хувь)-д хүргэхэд анхаарч усны нөөц нэмэгдүүлэх нөөцлөх бодлогыг дэмжинэ.
- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30%(хувь)-д хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 50%(хувь)-д хүргэхэд анхаарна.
- Орон сууцанд дулааны тоолуур тавих замаар өртөг зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлж, барилгын дулааны алдагдлыг 20%(хувь)-иар бууруулахад анхаарна. Саарал ус ашиглаж, хурын усыг хуримтлуулах, гадагшаа урсгалтай гол усыг нөөцлөх ажлыг дэмжинэ. Хог хаягдлыг цуглуулах тогтолцоог ядуурлыг бууруулах зорилттой уялдуулан хэрэгжүүлэхэд анхаарна.



- Ан агнуурын нөөцийн менежментийг сайжруулан, ховор ан амьтдын үржилийн болон нүүдлийн үеийн зан төрхийн судалгаа явуулж нөөцийг нэмэгдүүлэх тогтвортой ашиглалтын менежментийг хөгжүүлэхийг дэмжинэ. Орон нутгийн хөгжлийг дэмжих орлогыг шударга хуваалцах, ил тод байх зарчмыг нэвтрүүлэхийг дэмжинэ.
- Малчдын хамтын оролцоонд тулгуурлан тогтвортой ашиглах, бэлчээрийн талхлагдал, доройтлоос сэргийлэх, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх “Бэлчээрийн тухай хууль”-ийг батлуулахыг УИХ-ын байнгын хороодтой хамтран хэрэгжүүлнэ.
- Монгол орны говь тал нутгийг усаар хангах “Хэрлэн говь”, “Орхон говь” төслүүдийг хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

Хүний төлөө, ногоон, тохилог хотыг хөгжүүлэх. Цэгцтэй орон сууц, цэмцгэр гэр хороолол.

Шийдэл:

- Хотын төвийн газрын ашиглалтыг хуульчлан зохицуулахад анхаарна. Нягтаршил хэтэрсэн орон сууцны хороололд ногоон байгууламж, тоглоомын талбай, амралт зугаалга, автомашины зогсоолоос өөр төрлийн барилга шинээр барихыг хуулиар хориглоход анхаарч ажиллана.
- Түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтыг шинэчилж, төрийн хамгаалалтад авч хойч үедээ өвлүүлэх бодлого баримтлахыг бүх талаар дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд амьдралын таатай орчныг бүрдүүлэхэд анхаарна. Явган хүний зам, дугуйн замын стандартыг мөрдүүлж, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ.
- Шинэ суурьшлын бүс, дагуул хотыг хөгжүүлэхдээ төрийн өмчөөр төлөвлөлт хийж, дэд бүтцийг шийдвэрлэхэд онцгойлон анхаарна.
- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгохыг дэмжинэ. Гэр хороололд мод, ургамал тарих, арчилах иргэд, байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд анхаарна.
- Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндсэн суурь шийдэл нь нийслэл хотыг дүүрэг хотуудтай болгоход анхааран хууль эрх зүй эдийн засгийн бүх шаардагдах нөхцлүүдийг бүрдүүлэн бий болгоход анхаарна.

IV. ЦЭВЭР ТӨР, АВЛИГАГҮЙ УЛС ОРОН

Төрөө цэвэрлэж, хүчтэй болгож байж Монгол Улс сэргэн хөгжинө.

Улс орноо авлигаас ангижруулна. Улс орны төрийн албыг улс төрийн хүлээснээс чөлөөлж, улс төрийн зорилгоор наймаалцах, улс төрийн томилгоо, хууль бусаар төрийн албан хаагчийг халах байдлыг таслан зогсооход анхаарна. Мэргэжлийн ур чадвар бүхий ёс зүйтэй төрийн албан хаагчийг төрийн албанд тогтвортой ажиллах боломжийг хангана.



Шийдэл:

- Төрийн албаны зөвлөлийн хараат бус байдлыг хангуулж, төрийн албан хаагчийн мерит зарчмыг тууштай мөрдүүлж, хэвшүүлэхийг дэмжинэ. Төрийн албан хаагчийн шалгаруулалт нь тухайн ажлын байранд шаардлагатай мэдлэг, ур чадвараар шударга өрсөлдөх эрх зүйн баталгааг хангасан байхад анхаарна. Төрийн албан хаагчийг тасралтгүй сурах, хөгжих боломжоор хангах, давтан сургалт, ур чадварын шалгалтад таван жил тутам хамруулах арга хэмжээ авах, хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод, хүнээс хамаарал багатай болгосноор хүнд суртал болон үр ашиггүй, бүтээмжийг бууруулсан орон тоог багасгахад анхаарна.
- Төрийн хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг аль болох хөнгөн шуурхай хүнд сурталгүй болгоход анхаарч хүссэн иргэн бүр өөрт хамааралтай мэдээллийг чөлөөтэй авч болдог хуулийн тогтолцоог бүрдүүлэхийг дэмжинэ.

Эдийн засгаа авлигын торноос салгана. Төрийн албыг эрх мэдэлд хүрэх, тендер, концесс, ЖДҮ гэх мэт сан, улсын төсвөөс шимэгчлэн амьдрах үүр болгосон улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн далд-давхар эдийн засгийн гаж тогтолцоог нураахад анхаарна. Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгахад нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлогыг улс оронд хэрэгжүүлнэ.

Шийдэл:

- Засаглалын гаж тогтолцоо бий болох суурийг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийг илрүүлэн эрх зүйн шинэтгэлийг хийхэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.
- Авилгын сүлжээнд ороогүй, авилгатай тэмцэх улс төрийн чин хүсэл, ёс зүйтэй цэвэр төрийн албан хаагчид болон тэдний хамтын ажиллагаагаар төрийн албыг дэмжинэ.
- Төрийн өмчийн компаниудыг хөрөнгийн биржид бүртгүүлж, нээлттэй компани болгох замаар төрийн оролцоог эрс бууруулахад анхаарч, иргэдийн санал санаачлагыг дэмжинэ.
- Давхардсан үйл ажиллагаатай, хүнд сурталтай, алдагдалтай ажилладаг төрийн өмчийн компаниудын тоог цөөрүүлэн татан буулгах, хооронд нь нэгтгэн ашигтай ажилладаг болгох зөв менежментийг хэрэгжүүлэхэд анхаарна.
- Алдагдалтай ажилладаг Улсын үйлдвэрийн газрууд болон ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт мониторинг хийж, нээлттэй хувьцаат компани болгох, хувьцааг нь хөрөнгийн биржээр арилжих, хувьцааны ногдол ашиг тараадаг болгох, аль болох төсвөөс санхүүждэг байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Авилгын эсрэг нийтийн хөдөлгөөнийг идэвхижүүлнэ. Авлигын хэрэгт хатуу арга хэмжээ авч авилгыг устгах. Хүүхэд, залуу үедээ авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авилгыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн бүх гишүүдийн оролцоо, дэмжлэгийг авахад анхаарна.
- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт оновчтой чиглэсэн байх бодлогыг дэмжиж, хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид



ATA9693 9006109
9023030583

суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэхэд анхаарна.

Үндэсний аюулгүй байдал. Импортын хэт хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон, үнийн өсөлтөд өртөмтгий бүтэц бүхий Монгол Улсын ба орон нутгийн эдийн засгийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй байхад гол анхаарлаа хандуулж, дархлаа суулгах арга хэмжээг авч, өөрийгөө тэнцвэржүүлэх чадвартай, эмзэг бус, бие даасан эдийн засагтай болгох бодлогын цогц зөв зохистой тогтолцоог бүрдүүлэхэд анхаарна.

Шийдэл:

- Бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй байж, Монгол Улсын байр суурь, жин нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн алхмуудыг авч хэрэгжүүлэх төрийн бодлогод орон нутгийн болон иргэдийн санал санаачлагыг тусгахад анхаарна.
- Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэхийг дэмжинэ.
- Гадаадын хөрөнгө оруулалтыг аль болох боловсруулах болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбаруудад оруулах бодлогыг дэмжинэ.
- Эрчим хүч болон дэд бүтцийн салбарыг төрийн бодлогын эн тэргүүний зорилт болгоход онцгойлон анхаарч гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах урамшууллын болон хөнгөлөлтийн бодлого хэрэгжүүлэх бодлогыг бүх талаар урамшуулан дэмжинэ.
- Улс орны эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж болохуйц бүтээгдэхүүнийг үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл гэж үзэн түүний нөөцийг бүрдүүлэх, хамгаалах талаар төрийн онцгой анхаарах зүйл болгох бодлого боловсруулахыг дэмжинэ.

Хүн төвтэй Үндэсний аюулгүй байдлын цогц бодлогыг тууштай хэрэгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаанд анхаарна.

Шийдэл:

- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлэхэд анхаарна.
- Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих орон нутгийн хяналтыг эрс чангатгахад анхаарна.
- Үндэсний соёлын дархлаанд эрсдэл учруулж болох гадаадын хэт нөлөөнөөс монгол хүнийг хамгаалах зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлэхэд анхаарна.



**Батлан хамгаалах салбарын шинэчлэлийг эрчимжүүлэхэд төр,
засгийн дэмжлэг үзүүлнэ.**

Шийдэл:

- Батлан хамгаалах салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудал, орон сууцны асуудлыг өөрт нь болон улсын төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэхэд анхаарна.
- Цэргийн болон хилийн, тагнуулын байгууллагын ажиллагааг сайжруулж олон улсын нөхцөл байдалд зөв үнэлэлт дүгнэлт өгөх, хилээр үнэт метал, түүх соёлын өв, хар тамхи зэргийг хууль бусаар нэвтрүүлэх явдалтай хатуу тэмцэхэд төв орон нутгийн оролцоо туслалцааг дэмжинэ.
- Цэрэг эх оронч үзлийг залуусд бий болгох ажлын хүрээнд дунд болон их дээд сургууль МСҮТ-д батлан хамгаалах чиглэлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжинэ.

V. БАЯЛГАА ЗӨВ УДИРДАХ

***Байгалийн баялгийг эдийн засгийн зөв бодлогоор
бүгдэд хүртээмжтэй орлого болгох.***

Төсөв, мөнгө, гадаад худалдаа, татвар, үнэ, ханш, хүүгийн харилцан нягт уялдаатай, гадаад дотоод орчны өөрчлөлтөд түргэн зохицох макро эдийн засгийн ухаалаг удирдлагыг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх.

Шийдэл:

- Эдийн засгийг улс төрийн популизмаас ангижруулж, эдийн засгийн бодлогыг мэргэжлийн удирдлагаар хангах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд төв орон нутгийн оролцоог эрс нэмэгдүүлж, иргэдийн санал санаачлагыг хөхүүлэн дэмжих бодлого баримтална.
- Дотоод, гадаадын банкууд тэнцвэртэй ажиллах эрх зүйн орчинг нээх замаар бизнесийн зээлийн сарын хүүг 1%(нэг хувь)-иас доош буулгах бодлого баримтлахыг дэмжинэ.
- Нөхөн сэргээгддэггүй болон нөхөн сэргээгддэг байгалийн баялагт хандах төрийн бодлогод онцгой анхаарч тодорхой хөтөлбөр батлуулан үр ашигтай хэрэгжүүлэх бодлого баримтална.
- Хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгойлон анхаарч, иргэдийн хувьцаа эзэмших, худалдан борлуулах, өвлүүлэхэд анхааран дэмжинэ.
- Баялагийн хуваарилалтыг боловсронгуй болгосноор улс орны болон иргэдийн хөрөнгөөр баялагийн сан бүрдүүлэх төрийн бодлогыг тууштай дэмжинэ.

Өөрийн орны эдийн засгийн харьцангуй давуу тал дээр үндэслэн өрсөлдөх чадвар бүхий уул уурхай, мал аж ахуй, газар тариаланд түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэн, эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох бодлого баримтлана.

Шийдэл:

- Уул уурхайн олборлох салбарт тулгуурлан аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, нүүрс-хими, нефть-хими, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгнө.



00000010

- Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 50%(тавин) хувь, сүүний 50%(тавин) хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах хөтөлбөр төрөөс боловсруулан хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Улс орны дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйлдвэрт тэргүүлэх ач холбогдол өгч хөгжүүлэхийг дэмжинэ. Уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган, цемент, шилэн хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангахад төр, орон нутаг, иргэний оролцоог нэмэгдүүлнэ.

**Эдийн засаг, бизнест хэт дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий, шударга татварын тогтолцоог бий болгохыг дэмжинэ.
Бизнес хийхэд ээлтэй, шударга орчинг улс оронд бий болгоно.**

Шийдэл:

- Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөржүүлэх арга хэмжээ авна.
- Улс орны эдийн засаг, бизнесийн орчинг авилгагүй цэвэр болгох бүх л хууль эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгон олон шат дамжлага хүнд суртлыг төрийн үйлчилгээний бүх салбарт бүрэн арилгахад бүх талаар анхаарна.
- Бизнесийн олон төрлийг өргөжүүлэн өрхийн үйлдвэрлэлээс үндэсний үйлдвэрлэл хүртэлх бүх орчныг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгт онцгойлон анхаарч төрийн эн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болгохыг дэмжинэ.
- Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гадаад улс орнуудад экспортлох төрийн эрх зүйн баримт бичгүүдийг улам бүр боловсронгуй болгож, хурдан шуурхай үйлчилгээг төрийн бүх шатны байгууллагад нэвтрүүлэх, хувь хүн болон байгууллагын хуриуцлагыг өндөржүүлэхэд бүх талаар анхаарна.

МСДН нь энэ дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөөрөө Монгол улсдаа “Нийгмийн хамгааллын хүчтэй зөв тогтолцоог улс орондоо бий болгон хүн бүр хөдөлмөрлөн баялаг бүтээдэг, баялагаа зөв хуваарилан түүнээсээ ашиг хүртдэг шударга нийгмийг бүтээх” цогц бодлогыг хэрэгжүүлэх зорилго тавьсан болно.

